



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/418

Булган сум

Хүүхдийн зуслангийн сагсан бөмбөг,
волейболын талбайн тохижилтын ажилд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай" IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны "Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай" IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн зуслангийн сагсан бөмбөг, волейболын талбайн тохижилтын ажилд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Тохижилтын ажилд шаардагдах 14,000,000 (арван дөрвөн сая) төгрөгийг Булган Аймгийн засаг даргын Тамгын газар, Булган аймагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн гэрээний дагуу Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010579

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар 13... өдрийн 4/42 дугаар
захирамжийн хавсралт

Хүүхдийн зуслангийн сагсан бөмбөг,
волейболын талбайн тохижилтын ажилд
дэмжлэг үзүүлэхэд шаардагдах төсөв

№	Үйл ажиллагааны чиглэл	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Талбай цутгах бетон	М3	24	240,000	5,760,000
2	Бетон тээвэрлэлт	М3	24	90,000	2,160,000
3	Элс / волейболын талбайн/	портер	3	300000	900,000
4	Волейболын тор	ширхэг	2	150,000	300,000
5	Сагсны цагариг	ширхэг	2	110,000	220,000
6	Сагсны самбар	ширхэг	2	300,000	600,000
7	Талбайн будаг	М2	200	15500	3,100,000
8	Труба /150/	м	8	75000	600,000
9	Труба /100/	м	6	60,000	360,000
Нийт					14,000,000

-----oOo-----